



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД  
Б.ЧОЙЖИЛСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.11.14 № 01/18480  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээг нээлттэй, ил тод, хүртээмжтэй болгох, авлигын эрсдэл, шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж өгөх, арга зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж байна.

Энэ хүрээнд Эрчим хүчний яамнаас олгох тусгай зөвшөөрөл, дулааны болон цахилгааны техникийн нөхцөлтэй холбоотой тушаал шийдвэрийг хянан үзэж, хариуцсан албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулан холбогдох судалгаа мэдээллийг авч, түүнд дүн шинжилгээ хийхэд мэдээллийн ил тод байдал хангалтгүй, тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичгээр тодорхойлоогүй зэрэг нөхцөл байдал нь цаашид авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлтэй байх тул Зөвлөмжийг хүргүүлж байна.

Иймд Зөвлөмжид дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хариуг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 6. хуудастай.

ДАРГА,  
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

Авлигатай тэмцэх газрын  
2024 оны 11 дүгээр сарын 14 ны өдрийн  
О.И. дугаар албан бичгийн хавсралт

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

Эрчим хүчний яамнаас олгох тусгай зөвшөөрөл, дулаан болон цахилгааны техникийн нөхцөл олгохтой холбоотой дүрэм журам, тушаал шийдвэрийг хянан үзэж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж байна.

Зөвлөмж 1. Зөвшөөрлийн тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, тус хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1-14.22 дахь хэсэгт зааснаар эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгох тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг тодорхой болгох, тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах;

### **Нөхцөл байдал:**

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1-14.22 дахь заалт, Эрчим хүчний тухай хуулийн 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 20<sup>1.1</sup> дэх хэсэгт эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор заасан. Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгох бөгөөд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд зөвшөөрөл олгох бүрэн эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.”, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд заасан тохиолдолд эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, эсхүл Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 (холбоо төрийн бус байгууллага), 7.1.7 (нийтийн эрх зүйн хуулийн этгээд)-д заасан хуулийн этгээдэд шилжүүлж болно.” гэж, Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно.” гэж заасан.

Гэтэл хуулиар зөвшөөрөөгүй байхад Эрчим хүчний сайдын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/55 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалаар Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1-14.22 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрлийн өргөдлийг хүлээн авах, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах ажлыг зохион байгуулах эрхийг “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-д шилжүүлсэн байна. Улмаар тус төрийн өмчит компани нь 2023 оны 03 дугаар сараас эхлэн [license.energy.gov.mn](https://license.energy.gov.mn) тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч, хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах ажлыг хэрэгжүүлж байгаа нь зөвшөөрөл олгох бүрэн эрхэд хамаарах тул Эрчим хүчний сайдын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/55 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалыг хүчингүй болгох нь зүйтэй юм. Цаашид Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 4-т “Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон, эрх шилжүүлсэн бол хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болох бөгөөд үүсэх үр дагаврын зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон, эрх шилжүүлсэн этгээд хариуцна.” гэж заасныг анхаарах шаардлагатай байна

Түүнчлэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т “төрийн зарим нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх”, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6.2-т “Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.” гэсэн заалтын дагуу цаашид яамнаас тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг мэргэжлийн холбоодод шилжүүлэх зохицуулалтыг холбогдох хуульд бий болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, үүнтэй холбогдуулан мэргэжлийн холбоодыг чадавхжуулах асуудлыг бодлогын түвшинд хэрэгжүүлэх нь зүйтэй.

Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.7, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13, 14.14, 14.15, 14.16, 14.17, 14.18, 14.19, 14.20, 14.21, 14.22 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөл авахад стандартаар тогтоосон үйл ажиллагааны төрөл, суурь үзүүлэлтийг баримтална.” гэж заасан боловч холбогдох шаардлага нь өнөөг хүртэл батлагдаагүй. Гэтэл “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК нь эрх шилжсэн үеэс “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, угсралт, засварын ажил, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авахад тавигдах суурь нөхцөл шаардлагын стандарт<sup>1</sup>-ын төслийг баримтлан ажиллаж байгаа гэх бөгөөд хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн талаарх өргөдлийг хүлээн авч байгаа программаас шаардаж буй нөхцөл, шаардлагыг тодорхойлсон хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг байхгүй байгаа нь цаашид тодорхойгүй нөхцөл байдалд хүргэж, албан тушаалтанд эрх мэдлээ урвуулан ашиглах, дур зоргоор аашлах, эрх хэмжээгээ хэтрүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлтэй байна.

Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрх бүхий этгээд дараах үүрэг хүлээнэ”, 2.9-д “зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргах баримт бичгийн жагсаалт болон өргөдөл хүлээн авах этгээд, түүний хаяг, байршлын талаарх мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлэх”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.”, 8.5.1-т үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл” гэж заасан боловч Эрчим хүчний яамны energy.gov.mn цахим хуудаст зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргах баримт бичгийн жагсаалт, мэдээлбэл зохих бусад тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг байршуулаагүй байлаа.

Зөвлөмж 2. Эрчим хүчний яамнаас тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой үндэслэлгүй төлбөр тогтоон авч байгаа явдлыг судлан үзэж шийдвэрлэх, холбогдох дүрэм, журам, шийдвэрийг хүчингүй болгох, цаашид энэ төрлийн зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.

### **Эрх зүйн зохицуулалт:**

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох, сунгах болон зөвшөөрөлтэй холбогдох бусад харилцаанд доор дурдсан зарчмыг баримтална.”, 1.5 дахь заалтад “хуульд зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардахгүй байх” гэж заажээ.

<sup>1</sup> Эрчим хүчний яамны цахим хуудаст хэлэлцүүлэх стандартын жагсаалтад “Эрчим хүчний барилга байгууламж барих, засварлах, туршиж, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага”-ыг оруулсан байв.  
[http://www.energy.gov.mn/uploads/files/2\\_%D0%A5%D1%8D%D0%BB%D1%8D%D0%BB%D1%86%D2%AF%D2%AF%D0%BB%D1%81%D1%85%20%D1%81%D1%82%D0%B0%D0%BD%D0%B4%D0%B0%D1%80%D1%82%D1%8B%D0%BD%20%D0%B6%D0%B0%D0%B3%D1%81%D0%B0%D0%B0%D0%BB%D1%82\(3\).pdf](http://www.energy.gov.mn/uploads/files/2_%D0%A5%D1%8D%D0%BB%D1%8D%D0%BB%D1%86%D2%AF%D2%AF%D0%BB%D1%81%D1%85%20%D1%81%D1%82%D0%B0%D0%BD%D0%B4%D0%B0%D1%80%D1%82%D1%8B%D0%BD%20%D0%B6%D0%B0%D0%B3%D1%81%D0%B0%D0%B0%D0%BB%D1%82(3).pdf)

### **Нөхцөл байдал:**

Төрийн эрх бүхий байгууллагаас хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлөх мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох, хөнгөлөх, чөлөөлөх, төлөх, хураах болон түүнийг тайлагнахтай холбогдсон харилцааг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд тус хуулийн 23 дугаар зүйлд "Түлш, эрчим хүчний чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ"-г заасан. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох хэсгээр Эрчим хүчний яамнаас тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хэмжээг 12,500, 25,000, 37,500 төгрөг гэх зэргээр баталсан байна.

Гэтэл зөвшөөрөл олгох, сунгах болон зөвшөөрөлтэй холбогдох бусад харилцаанд хуульд зааснаас бусад төлбөр, хураамж шаардахгүй байх зохицуулалттай байхад "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК нь хууль зөрчин компанийн Гүйцэтгэх захирлын баталсан түр журмаар Эрчим хүчний яамнаас олгох тусгай зөвшөөрөлд үндэслэлгүй төлбөр тогтоон, төвлөрүүлж, зарцуулж байна.

Тодруулбал, "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний А/15 дугаартай "Түр журам батлах тухай" тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үнэ тооцох журам"-д үйл ажиллагааны төрлөөс хамаарч, Эрчим хүчний яамнаас олгох тусгай зөвшөөрлийн үйлчилгээний үнэ гэх байдлаар 200,000, 400,000, 600,000, 800,000, 1,000,000, 1,200,000, 1,600,000, 1,800,000, 2,400,000, 4,800,000 төгрөгөөр тус тус тогтоосон. Түүнчлэн "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК нь Эрчим хүчний яамыг төлөөлж, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй "Тусгай зөвшөөрөл эзэмших, эзэмшүүлэх гэрээ"-г байгуулж, тусгай зөвшөөрөл олгосон хугацаагаар /ихэвчлэн 5 жил/ үйлчилгээний хөлсийг НӨАТ-ын хамт 1 дор авдаг нь тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт дарамт чирэгдэл учруулж байгаа талаар зарим төлөөллүүд мэдээлж байна. Тухайлбал, хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрлөөс хамаарч улсын тэмдэгтийн хураамжаас гадна нэг удаад 1,100,000 төгрөгөөс 24,240,000 төгрөг төлж байгаа төдийгүй тус гэрээнд заасан үнийг барагдуулаагүй тохиолдолд "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-аас Эрчим хүчний сайдад уг тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг хүргүүлэх заалтыг гэрээнд тусгажээ. Тус төрийн өмчит компани нь тусгай зөвшөөрлийн үйлчилгээнээс 2023 онд 1,833,494,610 төгрөг, 2024 оны хагас жилийн байдлаар 601,186,299 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байдаг.

Иймд "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний А/15 дугаартай "Түр журам батлах тухай" тушаалын нэгдүгээр хавсралтаар "Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үнэ тооцох журам"-ыг хүчингүй болгох арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй юм. Харин үйлчилгээ үзүүлсний төлөө гарч буй зардлын хэмжээ нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасантай нийцэхгүй байгаа тохиолдолд хуульд өөрчлөлт оруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Зөвлөмж 3. Эрчим хүчний яамнаас олгох цахилгаан болон дулааны техникийн нөхцөлд үндэслэлгүй төлбөр тогтоон төвлөрүүлж байгаа дүрэм, журам, шийдвэрийг хүчингүй болгох, цаашид энэ төрлийн зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.

### **Нөхцөл байдал:**

Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм", "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 1.4-т зааснаар 1 мегавольт-ампер болон түүнээс дээш цахилгаан

ачаалалтай эсхүл цахилгаан эрчим хүчний эх үүсвэр шинээр барьж, эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох цахилгааны техникийн нөхцөл, 1 гигакалор/цаг болон түүнээс дээш дулааны ачаалалтай техникийн нөхцөлийг Эрчим хүчний яам нь тус тус олгож байна. Эрчим хүчний тухай хуулиар дулааны болон техникийн нөхцөл олгоход төлбөртэй байх талаар тусгайлан заагаагүй бөгөөд "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.18-д "Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл шинээр авах, сунгуулах, цахилгаан сүлжээнд холбуулахад эрх бүхий этгээдээс тогтоосон үйлчилгээний төлбөр (хураамж) төлнө.", "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.14-д "Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл шинээр авах, сунгуулахад эрх бүхий этгээдээс тогтоосон үйлчилгээний төлбөр (хураамж) төлнө." гэж тус тус заасан.

Мөн Эрчим хүчний сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/215 дугаар тушаалаар "Төсөл арга хэмжээний техник хяналтын зардал, тусгай зөвшөөрөл, цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын үйлчилгээний хураамжийг зарцуулах, тайлагнах журам"-ыг, 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/68 дугаар тушаалаар "Цахилгаан, дулааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэж, шийдвэрлэх ажлын хэсгийн ажиллах журам"-ыг баталсан боловч цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоогоогүй байна.

Гэтэл "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний А/21 дугаартай "Түр журам батлах тухай" тушаалаар "Техникийн нөхцөлийн үнэ тооцох журам"-ыг баталж, хэрэглээний цахилгаан, хэрэглээний дулаан, эх үүсгэврийн техникийн нөхцөлийн үнийг бүсчлэлээс хамааруулж тус тус тогтоожээ. Тодруулбал, бүсчлэлээс хамааран цахилгааны нөхцөл шинээр олгох тохиолдолд төвийн бүсэд 864,000 төгрөг, баруун бүсэд 2,844,000 төгрөг, зүүн бүсэд 1,681,200 төгрөг, өмнөд бүсэд 1,818,000 төгрөгөөр, чадлын ангилал, урьдчилсан шатны горимын тооцооллын дагуу 2,500,000-5,000,000 төгрөгөөр, холбогдох сүлжээний хувьд эх үүсгэвэр бол 1,500,000 төгрөг, дамжуулах сүлжээ бол 1,000,000 төгрөг, түгээх сүлжээ бол 500,000 төгрөг, хурлын зардал, бичиг хэрэг, техникийн нөхцөл олгох мэргэжилтэн ба инженер техникийн ажилтан нарын цалин хөлс 450,000, цахим системийн аюулгүй байдал 300,000 төгрөг гэх зэргээр тогтоосон. Түүнчлэн дулааны техникийн нөхцөл олгох үнэ нь цахилгааныхтай адил бөгөөд эх үүсгэвэртэй холбоотой үнэ нь суурилагдсан чадлаас хамаарсан байдлаар 5,000,000-6,000,000 төгрөгөөр тогтоосон, бусад нь цахилгааныхтай адил байв. Тус төрийн өмчит компани нь Эрчим хүчний яамнаас цахилгааны болон дулааны техникийн нөхцөл олгосонтой холбоотойгоор 2023 онд 1,114,588,430 төгрөг, 2024 оны хагас жилийн байдлаар 519,579,770 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

"Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-д цахилгааны болон дулааны техникийн нөхцөл олголтын үйлчилгээний хураамжийг тогтоох эрхийг хуулиар болон эрх бүхий этгээдээс олгоогүй байхад иргэн, хуулийн этгээдээс их хэмжээний төлбөр хураамжийг үндэслэлгүйгээр тогтоон төвлөрүүлж байгаа нь хууль зөрчсөн үйлдэл тул "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний А/21 дугаартай "Түр журам батлах тухай" тушаалаар баталсан "Техникийн нөхцөлийн үнэ тооцох журам"-ыг хүчингүй болгох арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй юм.

Түүнчлэн Эрчим хүчний сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/215 дугаар тушаалаар баталсан "Төсөл арга хэмжээний техник хяналтын зардал, тусгай зөвшөөрөл, цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын үйлчилгээний хураамжийг зарцуулах, тайлагнах журам"-ын 2.3-т "Тусгай зөвшөөрөл болон цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын хураамжийн төвлөрсөн орлогын 50

хувийг “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК, үлдэх хувийг Эрчим хүчний яам зарцуулна.” гэж заасан бөгөөд “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК нь 2023 онд тусгай зөвшөөрөл болон цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтоос нийт 2,948,083,040 төгрөг төвлөрүүлж, 621,125,182 төгрөгийг зарцуулсан. Зарцуулалтын байдлыг судлахад гадаад болон дотоод томилолтод 480,712,307 төгрөг /77,4 хувь/, техникийн нөхцөлийн зардалд 70,360,000 төгрөг /11,4 хувь/, горим системийн төлбөрт 60,536,875 төгрөг /9,7 хувь/, систем хөгжүүлэлтийн зардалд 9,516,000 төгрөг/1,5 хувь/-ийг зарцуулсан байв. Үүнээс үзэхэд тус компаниас тогтоосон төлбөрийн дүн нь тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөл олгох зардлаас хэд дахин давсан, нөгөө талаас гадаад болон дотоод томилолтод дийлэнх олонх буюу 77,3 хувийг зарцуулсан болох нь харагдаж байна.

Иймд эрх бүхий этгээд нь Захиргааны ерөнхий хуульд заасан хуульд үндэслэх, зорилгодоо нийцсэн, бодит нөхцөл байдалд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх зарчим, Төсвийн тухай хуульд заасан хариуцлагатай байх зарчимд тус тус нийцүүлэн зөвхөн үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлан батлах шаардлагатай байна. Түүнчлэн Эрчим хүчний сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/215 дугаар тушаалаар баталсан “Төсөл арга хэмжээний техник хяналтын зардал, тусгай зөвшөөрөл, цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын үйлчилгээний хураамжийг зарцуулах, тайлагнах журам”-ын тусгай зөвшөөрөл, цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын үйлчилгээний хураамжийг зарцуулах, тайлагнахтай холбоотой хэсгийг хасаж, журамд өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Зөвлөмж 4. Техникийн нөхцөл олгохтой холбоотой иргэн, хуулийн этгээдээс хүсэлт гаргах эрхийг хязгаарласан эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

#### **Нөхцөл байдал:**

Эрчим хүчний тухай хуульд дулааны болон техникийн нөхцөл олгохтой холбоотой нарийвчилсан зохицуулалт заагаагүй бөгөөд Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.8-д “Техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хүлээн авснаас хойш эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түгээгч, хангагч, дамжуулагч 14 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж, хариуг хүргүүлнэ.”, 2 дугаар хавсралтаар баталсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.6-д “Техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж тус тус заасан.

Өнөөгийн байдлаар цахилгаан, дулааны техникийн нөхцөлийг хүчин чадлаас хамааран эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цахилгааны техникийн нөхцөлийг түгээгч, хангагч эсхүл дамжуулагч, дулааны техникийн нөхцөлийг үйлдвэрлэгч эсхүл дамжуулагч, түгээгч, хангагч нар <https://itc.energy.mn/> цахим системээр дамжуулан олгож байна.

Энэхүү цахим систем нь сар бүрийн 1-10-ны өдрүүдэд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авахаар хөгжүүлэгдсэн бөгөөд техникийн нөхцөл олгогч байгууллагууд холбогдох журмууддаа “Техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг сар бүрийн эхний 10 хоногт цахим системээр хүлээн авна” гэх зэргээр заасан нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээ гаргах эрхийг хугацааны хувьд хязгаарлаж, чирэгдэл учруулах нөхцөлийг бүрдүүлж байна. Түүнчлэн эдгээр заалт нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтан дараах нийтлэг үүрэг хүлээнэ:”, 2 дахь заалтад

“харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг заавал хүлээн авах;” гэсэн заалтад нийцэхгүй байгаа бөгөөд иргэн сарын эхний 10 хоногт багтааж, хүсэлтээ хүргүүлж чадаагүй бол дараагийн сар хүртэл хүлээх шаардлагатай болж байгаа нь иргэнд хүнд суртал, чирэгдэл учруулж байна.

Иймд дараах төрийн байгууллага, албан тушаалтнаас баталсан журмуудын холбогдох заалтыг хуульд нийцүүлэн өөрчилж, цахим системийг сарын турш өргөдөл хүлээн авдаг болгох арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна. Хүснэгтээр харуулбал:

Д/д	Байгууллага, албан тушаалтны нэр	Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам	Огноо, дугаар	Холбогдох заалт
1.	Эрчим хүчний сайд	Цахилгаан, дулааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэж, шийдвэрлэх ажлын хэсгийн ажиллах журам	2023.03.02-ны өдрийн А/68 тушаалын хавсралт	3.1 (үүнтэй холбогдуулж шаардлагатай бусад)
2.	“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал	“Дулааны техникийн нөхцөл олгох журам”	2023.06.30-ны өдрийн А/97 тушаалын 2 дугаар хавсралт	3.3 (үүнтэй холбогдуулж шаардлагатай бусад)
3.	“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал	“Техникийн нөхцөл олгох комиссын ажиллах журам”	2024.04.01-ний өдрийн А/163 тушаалын 2 дугаар хавсралт	2.2 (үүнтэй холбогдуулж шаардлагатай бусад)

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР